



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 06 өдөр

Дугаар A/814

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Наран багийн Галданбошигт 1 дүгээр гудамжны 114 б тоотод байрлах худалдаа үйлчилгээний зориулалттай Дашzzэвгийн Пүрэвдаш /ПЭ88012819/-ийн эзэмшлийн 47.0 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Цэгмэдийн Түвшинжаргал /ПЭ75070908/-д шилжүүлэн, Цэгмэдийн Түвшинжаргал /ПЭ75070908/-ийн Наран багийн Галданбошигт 1 дүгээр гудамжны 114 а тоотод байрлах 000029080 газар эзэмших эрхийн гэрчилгээтэй 56 метр квадрат газартай нэгтгэн газрын хэмжээг 103 метр квадрат, хаягийг Галданбошигт 1 дүгээр гудамжны 114 тоот болгон 10 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэнд үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/814 Ch  
02 03994